

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 01 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Иргэний нисэхийн тухай хуулийг Улсын Их Хурал 2023 онд шинэчлэн баталсан бөгөөд уг хуульд иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газартай байна гэж заасан. Гэвч Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Иргэний нисэхийн ерөнхий газар байгуулахад шаардагдах төсөв, санхүүгийн асуудал тусгагдаагүй тул Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх хугацааг өөрчлөх агуулга бүхий хуулийн төслийг төсөл санаачлагч боловсруулсан байна.

Хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, санал хэлээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

